



Цахим шууданд

# ЦЭРГИЙН НАСНЫ ЗАЛУУЧУУДЫГ СУРГАЛТ, НӨЛӨӨЛЛИЙН АРГА ХЭМЖЭЭНД ХАМРУУЛАВ



**Өвөрхангай аймгийн ЗДТГ-ын Цэргийн штаб** 2022 оны I ээлжийн цэрэг татлагын ажлыг 4 дүгээр сарын 19-ний өдрөөс 5 дугаар сарын 02-ны өдрүүдэд Арвайхээр, Зүүнбаян-Улаан, Өлзийт, Баян-Өндөр, Сант, Баянгол, Төгрөг, Богд, Гучин-Ус сумдад хуваарийн дагуу зохион байгуулж байна.

Энэ удаагийн цэрэг татлагаар сумдын цэргийн насны залуучуудад сургалт нөлөөллийн арга хэмжээг мэргэжлийн байгууллагын сургагч багш нартай хамтран зохион байгуулж байгаа нь онцлогтой болж байна. Сургалт, нөлөөллийн арга хэмжээг нийгэмд өсвөр үе, залуучуудын оролцоо, үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэх, тэдэнд эрүүл мэнд, нөхөн үржихүйн боловсрол, эрх зүйн анхан шатны мэдлэг олгох, гэр бүл төлөвлөлт, гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх чиглэлээр зохион байгуулж байна.

Аймгийн ЗДТГ-ын Нийгмийн бодлогын хэлтсээс томилсон сургалтын багийн бүрэлдэхүүнд Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, Эрүүл мэндийн газар, Насан туршийн боловсролын төвийн мэргэжилтэн, сургагч багш нар ажиллаж, 9 сумын 1200 гаруй цэргийн насны залуучуудыг сургалт, нөлөөллийн арга хэмжээнд хамруулаад байна.

Дэд хурандаа Ч.АДЪЯА

Энэ удаагийн цэрэг татлагаар сумдын цэргийн насны залуучуудад сургалт нөлөөллийн арга хэмжээг мэргэжлийн байгууллагын сургагч багш нартай хамтран зохион байгуулж байгаа нь онцлогтой болж байна. Сургалт, нөлөөллийн арга хэмжээг нийгэмд өсвөр үе, залуучуудын оролцоо, үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэх, тэдэнд эрүүл мэнд, нөхөн үржихүйн боловсрол, эрх зүйн анхан шатны мэдлэг олгох, гэр бүл төлөвлөлт, гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх чиглэлээр зохион байгуулж байна.

Энэ удаагийн цэрэг татлагаар сумдын цэргийн насны залуучуудад сургалт нөлөөллийн арга хэмжээг мэргэжлийн байгууллагын сургагч багш нартай хамтран зохион байгуулж байгаа нь онцлогтой болж байна. Сургалт, нөлөөллийн арга хэмжээг нийгэмд өсвөр үе, залуучуудын оролцоо, үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэх, тэдэнд эрүүл мэнд, нөхөн үржихүйн боловсрол, эрх зүйн анхан шатны мэдлэг олгох, гэр бүл төлөвлөлт, гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх чиглэлээр зохион байгуулж байна.

## "2022 ОНЫ НЭЭЛТИЙН ХАРВАА"-Г ЗОХИОН БАЙГУУЛАВ



**"Алдар" спорт хороо** Энэ сарын 01-ны өдөр буюу зуны тэргүүн сарын шинийн 1-ны бэлэгт сайн өдөр Батлан хамгаалах яамны харьяа Зэвсэгт хүчний "Алдар" спорт хорооны Үндэсний сурын эрхий мэргэн харваачдын "2022 оны Нээлтийн Харваа"-г ҮБХИС дээр амжилттай зохион байгуулж дууслаа.

Харваанд эрэгтэй 30, эмэгтэй 21 улсын цолтой 12 харваач оролцов. Тэмцээний нээлтийн арга хэмжээнд ҮБХИС-ийн захирал бригадын генерал П.Жаргалан оролцож харваачдад амжилт хүсхийн зэрэгцээ Ардын хувьсгалын 100,101 жилийн баяр наадамд оролцох тамирчдын бэлтгэл сургалтыг дэмжиж ажиллахаа илэрхийлсэн юм.

Цэц мэргэн сорьсон ээлтийн харвааны эрэгтэй төрөлд нэгдүгээр байрыг Монгол Улсын гоц харваач Н.Алтансүх 36 оноогоор, 2 дугаар байрыг уриад сурын Улсын хошой мэргэн спортын мастер Н.Алтантулга 32 оноогоор, 3 дугаар байрыг Л.Сумхүү 31 оноогоор тус тус эзэлсэн бол эмэгтэй төрөлд 1 дүгээр байрыг Аймгийн гарамгай харваач Д.Мөнх-эрдэнэ 29 оноогоор, 2 дугаар байрыг Аймгийн гарамгай харваач н.Баасанжаргал 28 оноогоор, 3 дугаар байрыг Монгол Улсын мэргэн Б.Баярчимэг 28 оноогоор тус тус эзэллээ.

Энэ сарын 01-ны өдөр буюу зуны тэргүүн сарын шинийн 1-ны бэлэгт сайн өдөр Батлан хамгаалах яамны харьяа Зэвсэгт хүчний "Алдар" спорт хорооны Үндэсний сурын эрхий мэргэн харваачдын "2022 оны Нээлтийн Харваа"-г ҮБХИС дээр амжилттай зохион байгуулж дууслаа.



## ДЭСЛЭГЧ Ц.БАТ-ЭРДЭНЭ НЬ ДЭД БАЙР ЭЗЭЛСЭН АМЖИЛТ ҮЗҮҮЛЭВ



**Зэвсэгт хүчний 314 дүгээр анги** Монгол бүх ард түмний спортын XV наадам, Налайх дүүргийн их уурхай үүсэн байгуулагдсаны түүхт 100 жилийн ойн хүрээнд дүүргийн аварга шалгаруулах хөнгөн атлетикийн тэмцээний 5000 м зайн гүйлтийн тэмцээнд шатахуунаар зэрэг цэнэглэх тасгийн дарга дэслэгч Ц.Бат-Эрдэнэ нь дэд байр эзэллээ.

## ДАРХАН-УУЛ, БУЛГАН АЙМГИЙН СУРАГЧДАД ЭНХИЙГ САХИУЛАХ ҮЙЛСИЙГ СУРТАЛЧИЛЛАА

**Зэвсэгт хүчний 234 дүгээр анги** Тус анги Монгол Улс энхийг дэмжих ажиллагаанд оролцож эхэлсний 20 жилийн ойг тохиолдуулан орон нутгийн иргэд болон алба хаагчид руу чиглэсэн сургалт сурталчилгааны ажлыг олон хэлбэрээр зохион байгуулж байна.

Тухайлбал, хүүхэд залуусыг цэрэг-эх оронч үзэл хүмүүжлээр төлөвшүүлэх, иргэн-цэргийн харилцааг бэхжүүлэх, энхийг сахиулах үйлсийг сурталчлах хүрээнд өнгөрсөн сарын 27-ны өдөр Дархан-Уул аймгийн Ерөнхий боловсролын "Цайхун" сургуулийн 70 гаруй сурагч, Хялганат тосгоны дунд сургуулийн 9-12 дугаар ангийн сурагчдыг ангийн үйл ажиллагаатай танилцуулж, "Монгол Улсын Зэвсэгт хүчин энхийг дэмжих ажиллагаа дахь оролцоо-20 жил" сэдвээр мэдээлэл өглөө.

Сурагчид усчин дайчдын үйл ажиллагааны онцлог болоод энхийг дэмжих ажиллагааны ач холбогдлын талаар сонирхон асууж, "Монгол цэрэг-Дэлхийн цэрэг" хэмээн тодотгон, зарим хөвгүүд нь хугацаат цэргийн албаа заавал хаана гэдгээ уламжилж байсан юм.

Мөн ангийн хамт олны гар нийлэмжтэй байдал, нөхөрсөг харилцааг бэхжүүлэх зорилгоор "Хөгжөөнт буухиа" тэмцээн зохион байгуулахад 6 баг хурд хүч, авхаалж самбаагаа сорин өрсөлдсөнөөс ахлах дэслэгч Э.Ренчиндорж ахлагчтай Хөвүүр гүүрийн ротын нэгдүгээр баг, дэслэгч Ц.Анхзолбоо ахлагчтай Десант гатлалтын ротынхон тэргүүлж, Зам гүүрийн салааны баг болон хөгжөөн дэмжигчдийн дунд явагдсан тэмцээнд А.Мягмарсүрэн, Ч.Оюун-Эрдэнэ нар манлайлсан юм.



Дэслэгч Ч.ОЮУНЧИМЭГ

Дэслэгч Ч.ОЮУНЧИМЭГ

## "МАРАФОН-2022" ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ АЛБА ХААГЧИД АМЖИЛТТАЙ ОРОЛЦЛОО



**Зэвсэгт хүчний 284 дүгээр анги** Ангийн байр зүйн геодезийн хангалтын тасгийн зураг зүйн техникч агуулахын нярав ахлах ахлагч Х.Гал-Эрдэнэ 2022 оны 4 дүгээр сарын 30-ны өдөр Монгол Улсын хэт холын зайн гүйлтийн улсын аварга шалгаруулах тэмцээнд 50 км-ын зайд 4:48:30 секундтэй гүйж, ОУХМ цолтой 41 тамирчдаас шагналт VI байрт шалгарч амжилттай оролцлоо.



Мөн тус тэмцээнд Зэвсэгт хүчний 032 дугаар хэт холын зайн гүйлтийн улсын аварга шалгаруулах тэмцээнд 50 км-ын зайд 4:48:30 секундтэй гүйж, ОУХМ цолтой 41 тамирчдаас шагналт VI байрт шалгарч амжилттай оролцлоо.

Мөн тус тэмцээнд Зэвсэгт хүчний 032 дугаар хэт холын зайн гүйлтийн улсын аварга шалгаруулах тэмцээнд 50 км-ын зайд 4:48:30 секундтэй гүйж, ОУХМ цолтой 41 тамирчдаас шагналт VI байрт шалгарч амжилттай оролцлоо.

## НӨХӨРСӨГ ГАР БӨМБӨГИЙН ТЭМЦЭЭНИЙГ ЗОХИОН БАЙГУУЛЛАА



Орчин цагийн Зэвсэгт хүчин үүсэн байгуулагдсаны 101 жил, Монгол улсын Зэвсэгт хүчин НҮБ-ын болон олон улсын энхийг сахиулах ажиллагаанд оролцож эхэлсний 20 жилийн ойн хүрээнд Зэвсэгт хүчний 032 дугаар анги олон талт арга хэмжээнүүдийг зохион байгуулж байна.

Монгол цэргийн түүхэн замнал, анги байгууллагын ололт амжилтыг их, дээд сургуулиудын оюутан залуучуудад сурталчлан таниулах, тэдэнд цэрэг эх оронч үзлийг төлөвшүүлэх, Иргэн-цэргийн харилцааг бэхжүүлэх, хамтын ажиллагааг баталгаажуулах зорилгоор 2022 оны 04 дүгээр сарын 29-ны өдөр "Газарчин" дээд сургуулийн багш, оюутнуудтай нөхөрсөг гар бөмбөгийн тэмцээнийг амжилттай зохион байгууллаа.

Тэмцээнийг нээн зэвсэгт хүчний 032 дугаар ангийн захирагч хурандаа Ж.Мөнхбаяр хэлсэн үгэндээ Монгол улсынхаа ирээдүй болсон оюутан залуучуудад сурлага, спортын өндөр амжилт хүслээ.

Гар бөмбөгийн нөхөрсөг тэмцээнд "Газарчин" дээд сургуулиас эрэгтэй 2 баг, эмэгтэй 1 баг, Зэвсэгт хүчний 032 дугаар ангиас эрэгтэй ХЦАХ-чдын 2 баг, байнгын бүрэлдэхүүний 1 баг, эмэгтэй 1 баг тус тус оролцож хурд хүч, авхаалж самбаа, ур чадвараараа өрсөлдлөө.

Тэмцээн хамт олны халуун дулаан уур амьсгал, хөгжөөн дэмжигчдийн уухайн дунд сайхан болж өндөрлөлөө.

Ахлах дэслэгч Т.ДЭЛГЭРМАА